

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

/2024 оны 02 дугаа сарын 29-ний өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн хэмжээнд 23 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 20 гаруй хэрэглэгчээр буурсан үзүүлттэй байна. Оношилгооны чиглэлээр MRI шинжилгээний хүлээгдэл маш их, нийт 320 хүний хүлээгдэлтэй байна. КТГ оношилгоо хийлгэхээр 36, ходоод дурандуулахаар 27 үйлчлүүлэгч тус тус 3-аас дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

2024 оны 2 сард тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмнэлгийн хэмжээнд нийт 1221 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сараас 67 үйлчлүүлэгчээр буурсан байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Нүд судлал	17	28	120	530	695
2	Чих, хамар, хоолой судлал	19	52	97	152	320
3	Зүрх судасны эмгэг судлал	-	4	4	70	78
4	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	12	19	12	28	71
5	Урологи	9	10	4	-	23
6	Цусны эмгэг судлал	-	2	1	-	3
7	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	10	-	-	12
8	Дотоод шүүрэл судлал	2	3	-	-	5
9	Мэс засал судлал	10	2	-	-	12
10	Хэрх үе судлал	2	-	-	-	2
	НИЙТ	73	130	238	780	1221

Нүд, Чих, хамар, хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр хамгийн их иргэн хүлээж байна. Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 695 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн талаас илүү буюу 57%-ийг эзэлж байна. Мөн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 64% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх саруудтай ойролцоо хэмжээнд байна. Нийт 101 үйлчлүүлэгч амбулаторийн 11 чиглэлийн кабинетын эмчид үзүүлэхээр 4-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчийн үзлэг орж байна. Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	-	36	36
2	Бөөр судлал	-	-	20	20
3	Мэс засал судлал	-	2	9	11
4	Мэдрэл судлал	-	-	11	11
5	Эмэгтэйчүүд судлал	-	5	6	8
6	Нүд судлал	-	-	7	7
7	Зүрх судас	-	1	2	3
8	Уушиг судлал	-	1	1	2
9	Уламжлалт	-	1	-	1
10	Урологи	-	-	1	1
11	Чих хамар хоолой судлал	-	-	1	1
	НИЙТ	-	10	91	101

Нийт хүлээгдлийн дийлэнх илүү буюу 90% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 53 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Эход харуулахаар 29, рентген оношилгоо хийлгэхээр 15, MRI оношилгоо хийлгэхээр 9 үйлчлүүлэгч тус тус 2-с дээш хоног хүлээж байна. Лабораторийн шинжилгээ хүлээгдэлгүй байна.

Тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх сараас 66 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн, нийт 278 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэхээр 84, мэс заслын тасагт хэвтэхээр 48, уламжлалтын тасагт 42 хүн хэвтэн эмчлүүлэхээр тус тус ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 3.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	8	15	27	34	84
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	6	5	3	7	21
3	Чих, хамар, хоолой судлал	-	-	15	-	15
4	Уламжлалт эмчилгээний тасаг	-	11	10	21	42
5	Зүрх судасны эмгэг судлал	6	7	-	-	13
6	Мэс засал судлал	15	21	12	-	48
7	Урологи	5	3	2	10	20
8	Мэдрэл судлал	6	9	-	-	15
9	Уушиг судлал	7	3	-	-	10
10	Бөөр судлал	3	7	-	-	10
	НИЙТ	56	81	69	72	278

3. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдэл 1 сараас 100 гаруй хэрэглэгчээр буурсан боловч маш их хүлээгдэлтэй, нийт 413 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа		
		4-6 хоног	7-с дээш хоног	Нийт
1	Мэдрэл судлал	8	79	87
2	Зүрхний эмгэг судлал	1	77	78
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	17	15	32
4	Бөөр судлал	24	20	44
5	Булчирхай судлал	12	25	37
6	Зүрхний мэс засал судлал	5	4	9
7	Нүд судлал	7	7	14
8	Уушиг судлал	17	4	21
9	Чих хамар хоолой судлал	-	23	23
10	Мэс засал судлал	13	7	20
11	Мэдрэлийн мэс засал	2	9	11
12	Урологи	10	4	14
13	Зүрх/ хэм алдагдал/	-	14	14
14	Үе судлал	2	1	3
15	Уламжлалт	3	1	4
16	Сэргээн засах	1	1	2
	НИЙТ	122	291	413

Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 87, Зүрхний эмгэг судлалын эмчид үзүүлэхээр 78, бөөрний эмчид үзүүлэхээр 44 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Хүлээгдлэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 70% (291) нь 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 218 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна. Хүснэгт 5.

Хүснэгт 5. Улсын гуравдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Хэвлийн эхо	1	32	36	69
2	Зүрхний эхо	1	1	46	48
3	Зүрхний цахилгаан бичлэг	2	12	14	28
4	Доплер	1	7	4	12
5	Рентген зураг	1	3	5	9
6	Дуран	1	-	9	10
7	Тархины цахилгаан бичлэг	1	1	2	4
8	Холтер	-	-	8	8

Бүгд	8	86	124	218
------	---	----	-----	-----

Хэвлийн эхо-д харуулахаар 69 үйлчлүүлэгч, зүрхний эхо-д харуулахаар 48 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд тус тус хамаарч байна. Харин тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэл харьцангуй бага байна. Хүснэгт 6.

Хүснэгт 6. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Цусны шинжилгээ	20	5
2	Бактерлогийн шинжилгээ	5	-
3	Биохимийн шинжилгээ	18	3
4	Шээсний шинжилгээ	3	
5	Иммунологи	2	
	НИЙТ	48	8

Цусны шинжилгээ хийлгэхээр 25, биохимийн шинжилгээ хийлгэхээр 21 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэл шинжилгээнд хамаарч байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 188 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Мэдрэлийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 104, зүрх судасны тасагт хэвтэж эмчлүүлэхээр 34 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их орны хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 7.

Хүснэгт 7. Улсын гуравдугаар төв эмнэлгийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	25
		15-30 хоног	35
		1 сараас дээш	24
		Нийт	104
2	Уушигны тасаг	3-6 хоног	2
		7-14хоног	1
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	3
3	Мэдрэлийн тасаг	3-6 хоног	2
		7-14хоног	1
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	3
4	Нүдний тасаг	3-6 хоног	2
		7-14хоног	-
		15-30 хоног	2
		1 сараас дээш	-
		Нийт	4
5		3-6 хоног	5

	Чих хамар хоолойн тасаг	7-14хоног	2
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	7
6	Уламжлалт эмчилгээний тасаг	3-6 хоног	6
		7-14хоног	4
		15-30 хоног	2
		1 сараас дээш	-
		Нийт	12
7	Бөөр судлалын тасаг	3-6 хоног	6
		7-14хоног	2
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	8
8	Зүрхний мэс засал	3-6 хоног	6
		7-14хоног	-
		15-30 хоног	-
		1 сараас дээш	-
		Нийт	6
9	Зүрх судасны тасаг	3-6 хоног	6
		7-14хоног	23
		15-30 хоног	5
		1 сараас дээш	-
		Нийт	34
10	Мэс заслын тасаг	7-14хоног	7
		Нийт	7
	БҮГД	3-6 хоног	55
		7-14хоног	65
		15-30 хоног	44
		1 сараас дээш	24
		Нийт	188

4. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 148 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх саруудтай ойролцоо хүлээгдэлтэй байна. Гар сарвууны бичил мэс заслын эмчид үзүүлэхээр 56, Нурууны мэс засалд үзүүлэхээр 34, үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарна. Хүснэгт 8.

Хүснэгт 8. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Нурууны мэс засал	15	18	1	34
2	Хүүхдийн гэмтэл согогийн кабинет	5	-	1	6
3	Сэргээн засахын кабинет	7	1	-	8
4	Насанд хүрэгсдийн гэмтэл	28	5	-	33

5	Гар сарвууны бичил мэс заслын кабинет	41	12	3	56
6	Түлэнхий нөхөн сэргээн мэс заслын кабинет	-	2	-	2
7	Үений дурангийн мэс засал	-	2	-	2
8	Зүрх судас	2	-	-	2
9	Хавсарсан гэмтлийн мэс засал	-	-	2	2
10	Ясны гэмтлийн мэс засал	2	-	1	3
	НИЙТ	100	40	8	148

Бусад эмнэлгүүдтэй харьцуулахад хүлээгдлийн хоног харьцангуй богино, нийт хүлээгдэлтэй үйлчлүүлгэгчдийн талаас илүү буюу 67% нь 3 хоногийн хүлээгдэлтэй байлаа. ГССҮТ-д MRI оношилгооны төхөөрөмж гэмтэлтэй, ажиллахгүй байна. Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байв.

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 50 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 3 дахин буурсан байна.

6. Хүрээ амаржих газар ТМЭ

Тус эмнэлэг 2024 оны 2 сард хүлээгдэлгүй ажилласан байна.

7. Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв,

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Геронтологийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.